



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 19 өдөр

Дугаар А/372

Номгон

Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж,
нийтийн дэг журам, аюулгүй байдлыг
хангах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Гудамж, талбай, олон нийтийн бусад газарт хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актаар тогтоосон дүрэм, журмыг сахиулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн хэмжээнд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг 2024 оны 06 дугаар сарын 27-ны өдрөөс 06 дугаар сарын 29-ний өдрийг дуустал хугацаанд хориглосугай.

2.Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч улс төрийн нам, эвслийн үйл ажиллагаанаас ангид байх зарчмыг баримталж, хууль зөрчсөн үйлдэл гарахаас урьдчилан сэргийлж ажиллахыг нийт төрийн албан хаагчдад, төрийн албан хаагчдад хууль тогтоомжийг сурталчлан таниулах арга хэмжээг авч ажиллахыг сум, төрийн байгууллагын дарга, эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай.

3.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль зөрчсөн аливаа үйлдэлд өртөхгүй байж, түүнээс урьдчилан сэргийлэх, хууль бус үйл ажиллагаа явуулахгүй байхыг нийт иргэдэд уриалсугай.

4.Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, цагийн хуваарийг чанд мөрдөж, иргэдэд стандартын шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүн худалдаалахыг аж ахуйн нэгжийн захирал нарт үүрэг болгосугай.

5.Нутаг дэвсгэрийн хэмжээнд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль болон бусад холбогдох дүрэм, журмыг мөрдүүлэн, хэрэгжилтийг хангаж


• 82401069

2.

ажиллахыг сумын Засаг дарга нарт, Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй худалдаа, үйлчилгээний газрын үйл ажиллагаа эрхлэх цагийн хязгаарын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (Б.Мөнхбаяр)-т тус тус үүрэг болгосугай.

6.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН